

Увс аймгийн ИТХурал , Тэргүүлэгчдээс

2013 оны эхний хагас жилд хийсэн хийсэн ажлын тайлан

Нэг. Зохион байгуулсан ажил , үйл ажиллагааны үр дүн

Аймгийн ИТХ-ын стратеги төлөвлөгөө, 2013-2016 оны бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны чиглэлүүдэд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх, 2013 оны аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх болон НӨУБайгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаарх дэвшүүлсэн зорилтуудыг биелүүлж тайлагнах, аймгийн ИТХ-ын 2-4-р хуралдаанаар хэлэлцээд хурлын хороодоос өгсөн санал дүгнэлт, төлөөлөгчдөөс гаргасан санал шүүмжлэлд тусгагдсан асуудлуудыг шийдвэрлэх, хэрэгжилтийг хангахад аймгийн ИТХ-ын 2013 оны ажлын төлөвлөгөөний дагуу оны эхний хагас жилийн хугацаанд аймгийн ИТХурал, тэргүүлэгчдээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, гаргасан шийдвэрүүд нь чиглэж ирлээ.

Аймгийн ИТХ-ын ажлын төлөвлөгөөнд 2013 онд нийтдээ 125 ажил, арга хэмжээг зохион байгуулж хийхээр төлөвлөсний нь 67 бүрэн, 33 нь бүрэн бус буюу хагас, 29 ажил эхлэлийн шатанд явж төлөвлөгөө 53.6%-иар биелсэн, харин цаг үеийн шаардлагаар тэргүүлэгчдийн хурлаар 13 асуудлыг нэмж хэлэлцэн шийдвэрлэсний дээр 12 ажил арга хэмжээг нэмж хийлээ.

Аймгийн ИТХурал, ажлын алба 2013 онд 10 орон тоотойгоор 219.7 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт төсвийн 52.9% нь цалин урамшуулал, НДШ-д, 5.2% нь дотоод, гадаад томилолтонд, 5.7% нь тээвэр шатахууны зардалд, 2.6% нь бичиг хэрэгт, 2% нь шуудан холбоонд, 9.7% хуралдааны зардалд, 8.5% нь намын суудалд, 1.4% нь мэдээлэл сурталчилгааны ажилд, 2.1% нь нэг удаагийн зардалд, 3.1% нь ГХУСАЗөвлөлийн, 1.6% нь цагаатгалын комиссын ажилд, 2.8% нь ном хэвлэл, эд хогшил худалдан авах, 3% гаруй нь төлбөр хураамж бусад зориулалтаар тус тус зарцуулагдаж, төсөв хүрэлцэхгүйгээс давсан орлогоос нэмэлт санхүүжилт авч, томоохон ажил арга хэмжээг бусад гадны эх үүсвэрийн дэмжлэгээр зохион байгуулж байна.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтцийг тогтоох тухай Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд удирдах, бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах гэсэн 3 шатлалтай ажиллахаар шинэчлэн тогтоож, тэдгээрийн ажлын байрны зорилгыг батласны дагуу ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, ажлын албаны дарга, хууль, эрх зүй дотоод ажил эрхэлсэн ахлах мэргэжилтэн, эдийн засаг, өмчийн харилцаа эрхэлсэн ахлах мэргэжилтэн, олон талт хамтын ажиллагаа, маркетингийн мэргэжилтэн, НӨУБ-ын харилцаа хамтын ажиллагааны мэргэжилтэн, харилцаа хамтын ажиллагаа, түншлэл, мэдээллийн мэргэжилтэн, дотоод ажил, архив бүртгэлийн мэргэжилтэн, санхүү, нябо бүртгэлийн мэргэжилтэн, нярав, жолооч гэсэн орон тоогоор ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэг явуулж батлан мөрдөн ажиллаж байна. Аймгийн ИТХ-ын ажлын албаны мэргэжилтнүүд нь ажлын байрны тодорхойлолтынхоо дагуу 2013 онд аймгийн ИТХ-д

нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт, өөрийн хариуцах асуудлаар үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, нэгжийн менежертэй үр дүнгийн гэрээтэй, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нь аймгийн ИТХ-ын даргатай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээтэй ажиллаж байна. Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрэм, ашиг сонирхолын зөрчилгүй ажиллах гэрээгээр харилцан үүрэг хүлээж, түүний дүнг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг тооцох, үр дүнгийн гэрээг дүгнэхэд харгалзан үздэг боллоо.

Мөн түүхэн танилцуулгын булан, Хурлын хороод болон төлөөлөгчид ажиллах интернетийн сүлжээ бүхий танхимыг байгуулав. Хурлын дарга, мэргэжилтнүүдийн өрөөнд их засварын ажил хийж, шинэчлэн тохижууллаа.

2013 оны 1-р сараас эхлэн сумдад иргэний танхим байгуулах, ажиллуулах шийдвэр гаргаж иргэний танхимын ажилтны ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, иргэдэд хууль, эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ, хэлэлцүүлэг зохион байгуулах чадвар бүхий эрх зүйч мэргэжилтэй ажилтанг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөөс 6 хүнийг, 13 ажилтанг төрийн албанд нээлттэй сонгон шалгаруулж, томилон ажиллуулав.

Сумдын ИТХ-ын төсвийн менежерүүдэд санхүүгийн тэмдэг захиалан хийлгэж хүлээлгэн өглөө. Хуралдаан, семинари сургалтын бэлтгэл хангах төлөвлөгөө, хөтөлбөр зэрэгт холбогдох талуудын санал авч боловсруулах, хэлэлцүүлэн батлуулах ажил хийгдлээ.

Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд зэрэг ажлын 9 байранд сонгон шалгаруулалт явуулах захиалгыг ТАЗ-д өгч тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэв.

Хурлын хороод 8 хяналт, боловсруулалтын ажил хийхээр төлөвлөснөөс Тэргүүлэгчдийн болон хуралдаанаар хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хуралдааны бэлтгэл хангах асуудлаар тус бүр 4-6 удаа, эмэгтэй төлөөлөгчдийн бүлэг 1удаа хуралдаж, хяналт шалгалт явуулах, судалгаа хийж санал дүгнэлт гаргах, баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ажил зохион байгуулж энэ ажилд төлөөлөгчдөө жигд татан оролцуулж Хороог тасралтгүй ажиллуулахад анхаарч байна.

Аймгийн ИТХ-ын 41 төлөөлөгчдөд цахим технологи нэвтрүүлэх худалдан авалт зарлаж, шалгаруулалт явуулж, бүтээгдэхүүнийг нийлүүлснээр 2-р хуралдааны төгсгөлд IPAD-тай болгож мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр төлөөлөгчид e-mail хаягтай болж зар мэдээ, хуралдааны танилцах материалыг цахим хэлбэрээр авч, мэдээ тайлангаа ирүүлдэг болж, ажилдаа цахим мэдээллийг байнга ашиглаж хэвшлээ.

Төрийн хууль тогтоомж, аймгийн ИТХ-ын шийдвэрийг иргэд, байгууллагуудад сурталчлах зорилгоор нээлттэй утас, веб хуудас ажиллуулах, багийн ИНХ-аар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлыг хэлэлцүүлэн иргэдийн саналыг авч эрэмбэлүүлэх, сумын бүх төсвийн байгууллагууд, зарим төрийн албан хаагчдын үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгүүлэх, ИТХ-ын хуралдааны материалын нэг хувийг аймгийн номын санд тавьж олон нийтэд танилцуулах, “шинэ мэдээ”-г мэдээллийн самбарт тавьж, орон

нутгийн сонин болон телевизээр дамжуулан сурталчлах, орон нутгийн 2 телевизтэй жилийн гэрээ байгуулан ажиллаж, мэрэгжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах зорилгоор бичмэл сэтгүүлийг 1 удаа гаргаж, гарын авлага болгон “ИТХ, Хурлын төлөөлөгч хэрхэн ажиллах вэ?, Иргэдийн төлөөлөгчдийн Хурал- түүнтэй холбоотой зарим асуудлууд” зэрэг номууд, хуулиудыг захиалан авч аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХурлууд, багийн ИНХ-ын дарга нарыг хангаж байна.

Аймгийн ИТХурал, тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрүүдийг аймгийн Засаг дарга, түүний тамгын газар, харьяа хэлтэс, газрын удирдлага, сумдын Засаг дарга, Тамгын газруудад тухай бүрийд нь хүргүүлж, Хурлын болон тэргүүлэгчдийн хуралдаан дээр Засаг дарга, Тамгын газар, хэлтэс, газруудын ажилтай холбоотойгоор гарсан болон Улаангом сумын багийн ИНХ-ын ОНХС-ийн хэлэлцүүлэгээр иргэдийн гаргасан 452 санал шүүмжлэлийг 23 албан байгууллага, холбогдох албан тушаалтанд 29 албан тоотоор хүргүүлснээс 11 байгууллага хариуг ирүүллээ. Нийт 71 саналын мөрөөр тодорхой ажил зохион байгуулагдаж, 9 асуудлыг ЗГХЭГ, яаманд уламжилж, 167 саналыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгаж, 104 ажлыг сум, орон нутаг, байгууллагуудад шийдвэрлүүлэхээр шилжүүллээ.

Албан байгууллагуудаас ирүүлсэн хариуг санал шүүмжлэл гаргасан төлөөлөгч бүрт, мөн холбогдох Хурлын хороодод тухай бүрт цахимаар хүргүүлэхийн зэрэгцээ Хурлын төлөөлөгчдийн ажлын өрөөнд тавьж танилцуулж байна.

Сумдын ИТХ-ын дарга нарт 2, сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт 1, бүх багийн Засаг дарга нарт 1 удаа тус тус ажил төрлийн семинар, захиалгат сургалт зохион байгуулав.

Аймгийн ИТХ-аас зохион байгуулж байгаа ажлын явцын сар бүрийн мэдээ, цаашид мөрдөж хэрэгжүүлэх, арга зүйн баримт бичгүүд бусад мэдээллийг агуулсан “Шинэ мэдээ” сэтгүүлийг сар бүр бэлтгэн хэвлэж сумдын ИТХ, аймгийн төлөөлөгчдөд хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-аас баталсан удирдамжийн дагуу аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, ажлын алба, ЗДТГ-тай хамтарсан 9 ажлын хэсгийг томилон ажиллуулж Хурал, иргэний танхимын болон сумын ажилтай танилцаж, зөвлөмж, чиглэл өгч, цаг үеийн ажлаар иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонсож, сумдад ажилласан дүнг үндэслэн аймгийн ИТХ-аас сум, багийн ИНХ, иргэний танхимын ажлыг улам боловсронгуй болгож сайжруулах тухай аргачилсан зөвлөмж гаргаж хүргүүлэв.

Аймгийн ИТХ-аас 2013 оны эхний хагас жилд 4 удаа уулзалт, семинар, сургалт цугларалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс нийтдээ 8 удаагийн арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарын 3 өдрийн сургалтыг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулав. Багийн Засаг дарга нарын семинар хийж багийн ИНХ-д иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, багийн ИНХ-ын болон Засаг даргын хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх талаар мэдээлэл, зөвлөмж өглөө. Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, аймгийн ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар ЗГХЭГ-аас зохион байгуулж буй “Шууд ардчилал, иргэдийн оролцоотой төсвийн менежмент” үндэсний сургалт, зөвлөгөөн, “Бичил уурхайн тулгамдсан асуудлаар зөвлөлдөх уулзалт”, Орон нутгийн удирдлагын нэгдсэн сургалтанд хамрагдав.

Сангийн яамнаас зохион байгуулсан Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх “Орон нутгийн төсвийн шинэчлэл” сургалтанд 19 сумын ИТХ-ын дарга нарыг оролцууллаа. Сумдын хурлын нарийн бичгийн дарга нарт Төсвийн хуулиар сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу аймгийн ИТХ-аас зохион байгууллаа.

Мерси Кор олон улсын байгууллага, “Сайн тус” ТББ-тай хамтран сумын иргэний танхимын ажилтны арга зүйн сургалт, туршлага солилцох уулзалтыг явууллаа. Тус арга хэмжээнд 18 сум хамрагдаж иргэний танхим ба сумын ИТХ, ЗДТГ-ын хамтын ажиллагаа, иргэдэд үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээний талаар зөвлөмж өгч, сумын иргэний танхимын ажилтнууд нэгдсэн ойлголтонд хүрлээ. Сайн засаглал, иргэний оролцооны талаарх Монгол улсын төрөөс баримталж буй бодлого, оролцоо, түүний ач холбогдол, иргэдийг хэрхэн идэвхижүүлэх, иргэний танхимын гүйцэтгэх үүрэг, хэлэлцүүлэг чиглүүлэгчийн үүрэг, мэдээлэл түгээх, саналыг оруулан хэлэлцүүлэх, саналыг эрэмбэлэн дэмжих, ажлын төлөвлөгөө, тайлан мэдээ боловсруулах аргачлал, удирдлагын цогц систем Able программын ашиглалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, архив бүртгэл, баримт бичгийн стандартын сургалт семинар зохион байгууллаа. Бусдыгаа манлайлан ажиллаж байгаа Бөхмөрөн, Давст, Зүүнговь, Цагаанхайрхан сумын иргэний танхимын ажилтанууд өөрсдийн туршлагаа танилцуулав.

Зүүнговь, Бөхмөрөн, Ховд сумын ИТХ худалдан авалтаа хийж иргэний танхимаа иж бүрэн тохижуулж дууссан, бусад суманд худалдан авалт зарлагдсан, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх, засвар тохижилтын ажил хийгдэж байна.

Аймгийн сонгуулийн хороог бүрдүүлж ажиллуулах, сонгуулийн бэлтгэл хангаж зохион байгуулахад аймгийн ИТХ, хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн биелүүлж аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргыг сонгуулийн хорооны даргаар, хорооны бүрэлдэхүүнд нэг мэргэжилтэнг томилон ажиллуулав. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэлийг хангахтай холбогдуулан 19 сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт 1 өдрийн сургалт, 88 хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд сумдад нь очиж сургалт зохион байгуулав. Аймгийн төв бүх суманд “Сонгогч танаа” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулав. Иргэний бүртгэлийн хэлтсээс иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнуудад 3 өдрийн сургалт семинари, мэдээлэл технологийн багийнхан сумдын техникийн даамлуудад 2 өдрийн сургалт тус тус зохион байгуулж, ВИСАТ сансрын антенныг сүлжээ байхгүй 5 хэсэгт байрлуулж, санал тоолох ISP машиныг сумдад хүргэх, татан авах ажлыг зохион байгууллаа. Сонгуулийн санал авах өдөр хөдөлгөөнт 5 баг ажилласан. Өлгий, Өмнөговь суманд unitel-ийн сүлжээ тасарснаас болон ВИСАТ сүлжээ Түргэн суманд ажиллаагүйгээс мэдээ дамжуулалт саатсныг шуурхай арга хэмжээ авч хэвийн горимд оруулав.

Аймгийн сонгуулийн хороо сумдаас ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг тухай бүрт нь шийдвэрлэж хариу мэдэгдэж ажилласны дээр аймгийн сонгуулийн хорооны гишүүд санал авах бэлтгэл ажлын явцтай танилцаж заавар зөвлөгөө өгч, саналын хуудас хүргэх ажлаар бүх сумдад явж ажиллах зэрэгт нь техник унааны туслалцаа үзүүлж ажиллав.

СЕХ-оос ирүүлж буй санал хураалтын дүнгийн нэгтгэлтэй холбоотой санал хүчингүйд тооцох, хүчингүй саналын хуудас зэргийн мэдээний маягтыг хуулинд нийцүүлэн ойлгомжтой болгох, аймаг, сумын сонгуулийн хорооны бүтцэд ажиллаж буй төрийн албан хаагчдын урамшууллыг нэмэгдүүлэх, Иргэний бүртгэлийн газраас ирүүлж буй сонгогчдын нэрсийн жагсаалтыг ямар нэгэн зөрүүгүйгээр гаргаж байх хэрэгтэй. Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтны ихэнх нь багш нар ажилласан. Гэтэл Боловсрол, шинжлэх ухааны яамны сургалтын графикайн дагуу цугларалт зохион байгуулснаас сонгогчдын шилжих хөдөлгөөнийг хийх, нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн эсэхэд тулгалт явуулах зэрэг ажлыг тасалдуулахад хүргэж, бэрхшээл үзүүлж байсан тухай сумдын ИТХ-аас мэдээлснийг цаашид анхаарах хэрэгтэй байна.

Сонгууль зохион байгуулах бэлтгэл ажил, байр, техник хүний нөөцөөр хангах, удирдлага зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх ажлыг Аймгийн ИТХ-ын ажлын алба үндсэнд нь гүйцэтгэлээ.

МНУХ, Мерси Кор ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Сумын мастер төлөвлөгөө боловсруулах” төсөлд хамрагдах Завхан, Өлгий, Малчин, Өндөрхангай, Давст, Улаангом сумуудын өргөдлийг хүргүүлж, уг төсөлд хамрагдан “Иргэдийн оролцоо ба орон нутгийн хөгжлийн төлөвлөлт” сургалт семинарт аймгийн болон дээрх сумдаас 10 төлөөлөл оролцлоо.


ИТХ-ын ажилтан, сонгуультны мэргэжил арга зүйн гарын авлага болох “Нутгийн удирдлага” сэтгүүлийн захиалгын байдалд хяналт тавьж, захиалгаа нэмэгдүүлэхийг сумдын ИТХ-д зөвлөсний дүнд сэтгүүлийн нэмэлт захиалга 66-аар нэмэгдэж, 2-р улиралд 499 ширхэгийг захиалсан.

Мэдээлэл технологийн хөгжлийн шинэ нөхцөлд ажиллаж сурах шаардлагыг харгалзан “Цахим–Увс” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн ИТХурал манлайлан оролцож аймгийн НӨУБайгууллагуудын мэдээ мэдээллийн шуурхай байдлыг хангах, цаасгүй мэдээллийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд аймаг, сумын ИТХ-аас хийсэн ажлын онцлох мэдээг сар бүрийн “Шинэ мэдээ” -нд тусгуулж сар бүрийн ажлаар мэдээллийн сан үүсгэж байна. Мэдээллийн шинэ тогтолцоо бүрдүүлэх талаар Аймгийн ИТХ нь албан ёсны вэб сайт /www.khural.uv.gov.mn/-тай болов.

Мөн Facebook сайтанд групп / www.facebook.com/groups/uvsv.ith/ хаягтай боллоо. Аймгийн ИТХ-ын нийт төлөөлөгчдөд мэдээллийг цаг алдалгүй хүргэх, харилцан мэдээлэл солилцох техник хангамжийг сайжрууллаа. Төрийн байгууллагуудын нэгдсэн программ болох удирдлагын цогц систем ABLE программыг нэвтрүүлж 47 байгууллага 1217 албан хаагчид нэвтрүүлж ашиглан мэдээллээ түргэн шуурхай солилцон ажиллаж, төрийн байгууллагын уялдаа холбоог хангах нөхцлийг бүрдүүлж аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэрийг иргэдэд мэдээлж байна.

2013 оны эхний хагас жилд дундажаар сумдын ИТХурлын хуралдаан 24 удаа, Тэргүүлэгчдийн хурал 126 удаа, багийн ИНХурал 162 удаа тус тус хуралдаж орон нутгийн цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 226 асуудал хэлэлцэн 1445 заалт бүхий 578 тогтоол гаргажээ. Үүнд:

Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудал



Цагаанхайрхан сумын ИТХ-аас тэргүүлэгчдийн хурлаар асуудал оруулагчид 5-7 хоногийн өмнө мэдэгдлийг хүргүүлж бэлтгүүлээд хуралдаан болохоос 3 хоногийн өмнө зарын хамт Тэргүүлэгчдэд хүргүүлэн танилцуулж, зарын самбараар хуралдаан болох газар, хугацаа, хэлэлцэх асуудлыг сурталчилж иргэдийн саналыг авч, шийдвэрт тусгаж байгаа, **Өндөрхангай** сумын ИТХ-аас сумын төвийн дахин төлөвлөлт, тохижилтын талаар хэлэлцүүлэг хийж, иргэдийн саналыг нь авсан, **Давст** сумын ИТХ-аас тэргүүлэгчдийн хурлаа өргөтгөн хийж сургууль, цэцэрлэг, тамгын газар, эмнэлэг, соёлын төв, цагдаагийн тайланг хэлэлцүүлж иргэдээр үнэлэлт дүгнэлт өгүүлсэн, **Баруунтуруун** сумын ИТХ хуралдааныг орон нутгийн телевизээр шууд нэвтрүүлэхийн зэрэгцээ шууд утас 2-ыг ажиллуулж иргэдийн саналыг сонсож шийдвэрт тусган иргэдийн шууд оролцоог нэмэгдүүлсэн, **Улаангом** сум сар бүрийн гуравдахь долоо хоногийн 15 цагт тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг хийдэг болсон, Баруунтуруун, Зүүнговь, Түргэн сумд ИТХ-ын төлөөлөгчдөө МНУХ-ны сургалтанд хамруулахаар бэлтгэл ханган ажиллаж байгаа, **Өлгий, Давст, Цагаанхайрхан, Завхан, Сагил, Тэс, Малчин, Баруунтуруун, Өндөрхангай, Улаангом** сумд багийн ИНХ-ын дарга нарт сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Цагаанхайрхан сум: Иргэдийн дунд “Архийг хэдэн цагаас хойш худалдахгүй байх вэ ” гэсэн санал асуулга утсаар явуулж, иргэдээс гарсан санал хүсэлтийг Засаг даргад хүргүүлэн 18

цагаас хойш архи худалдахгүй байх захирамж гаргуулан архи худалдаж буй 8 дэлгүүрт хүргэж ЗЗНДНТУТ хууль, АСТ тухай хууль, ГХУС тухай хуулийн талаар мэдлэг өгсөн.

Ховд сум: 4 багийн иргэдийн нийтийн хурлыг хийж Багийн засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ИНХ –ын үндсэн чиглэл, сургуулийн, эрүүл мэндийн төвийн ажлын тайлан, ЖДҮ –ийг хөгжүүлэх чиглэл тогтоох санал авах зэрэг асуудлуудыг хэлэлцэж холбогдох шийдвэр гарган ажиллаж байгаа

Зүүнговь: ЖДҮ-ийг дэмжих сангаар санхүүжүүлэх төслийг багийн ИНХ-аар хэлэлцүүлж, илээр санал хурааж, төслийг эрэмбэлж 8 төсөл шалгаруулсан. Төслүүдийн хэрэгжилт, үр дүн сайн байна. 50458002 дугаарын нээлттэй утас ажиллуулсан.

Өмнөговь сум: Сумын нутаг дэвсгэр Салхит хэмээх газар хууль бусаар алт олборлосон нийт 50 гаруй нүхийг таглах, нөхөн сэргээх ажлыг 2 өдөр хийсэн.

Баруунтуруун сум : Модон түлшний хэрэглээг бууруулах замаар түлшийг зөвхөн ахуйн хэрэгцээнд биш аж ахуйн хэрэгцээгээр илүү ашиглаж болох талаар тогтоол гаргаад иргэддээ идэвхитэй сурталчилж байна. Сумын ИТХ-ын 70456114 нээлттэй утас ажиллуулж эхэлсэн

Өндөрхангай сум: Сумын ИТХ-ын 1-р улирлын тайланг сонин хэлбэрээр хэвлэж сумын төвийн бүх өрхүүдэд тарааж өгөв. Хөдөөгийн багуудын аялах хайрцагт хийж мөн ИТХ-ын төлөөлөгчдөд өгч багийн иргэдэд тайланг танилцуулж үнэлгээ дүгнэлт өгүүлэх үүрэг даалгавар өглөө. Хан Хөхийн нурууны УТХГН-ийн захиргаа болон төсөвт байгууллагуудтай хамтран 4-р сард “Байгаль хамгаалал-Цэвэр орчин” аян зохион байгуулж сумын төвийн 8 орчим км газрыг цэвэрлэсэн байна. Сумын төвийн дахин төлөвлөлт, тохижилтын талаар иргэдээр хэлэлцүүлж саналыг авсан нь иргэдийн оролцоог дээшлүүлэх, идэвхитэй оролцох, өөрсдийн тулгамдаж байгаа асуудлаа шийдвэрлэх шинэлэг санаачлагатай ажил болсон.

Малчин сум: Сумын ИТХ-аас хөдөөгийн 3 багийн ядуу амьдралтай өрхийн судалгааг явуулж багийн ИНХ-аас танилцуулан шийдвэр гаргуулан баг тус бүрт 2 өрхийг малжуулах төслийг иргэдийн оролцоотойгоор амжилттай хэрэгжүүлсэн байна. Энэ төслийн үр дүнд иргэн Б.Бөхболдод 70, П.Ширнэнд 50, Ж.Отгонхуягд 50, Х.Батболдод 50, Т.Энхтайванд 60, Б.Баточирт 50 нийт 330 толгой малын дэмжлэг үзүүлсэн.

Хяргас сум: Сумын ИТХ-ын зохиосон олон нийттэй харьцах ажлын үр дүнд Тээвэрчдийн холбоо байгуулагдаж, холбооны тэргүүнийг сонгож, 11 тэргүүлэгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Энэ холбоо амьжиргааны түвшинээс доогуур орлоготой иргэн Ц.Төмөртогод хашаа байшин барьж өгөх, авто техникийн улсын үзлэгийн үеэр жолооч бүр 1 машин хайрга ачиж буулгах ажлыг зам тэгшлэхэд зориулж хийхээр болсон.

Давст сум: Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааныг өргөтгөн хийснээр иргэдийн тулгамдсан асуудлуудыг нээлттэйгээр хэлэлцүүлж тэдний санал дүгнэлтийг сонсож оролцоог нь нэмэгдүүлсэн арга хэмжээ болсон ба сумын ИТХ-ын төлөөлөгч, багийн ИНХ-ын дарга, засаг

дарга нарын сургалт нь тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үр дүнгээ өгсөн сургалт болсон.

АНУ-ын Азийн сантай хамтран Өмнөговь суманд Байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, хариуцлагатай ашиглалтыг бий болгох, түүний өгөөжийг тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад талуудын идэвхитэй, бүтээлч оролцоог бий болгох зорилго бүхий нутгийн захиргаа, иргэд, хувиараа алт олборлогч иргэдийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэй “Олон талт зөвлөл”-ийг байгуулж, түүний ажиллах журам, 2013 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлуулсан.

Азийн сангаас олгосон голын усны чанар, хөрсний шинжилгээ хийх хянах тест, иж бүрэн багаж хэрэгсэлүүдээр Өмнөговь сумын Намирын гол, Тариалан сумын Хархираа голд сумдын ахлах сургуулийн биологийн багш, сумдын ИТХ-тай хамтарсан зөвлөл усны чанарт хяналт хийн, жилийн ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа зэрэг шинэлэг эхлэл санаачлагууд гарч байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс баталсан “Аймгийн оны аврага тэргүүнийг шалгаруулах, сум, агентлаг, аж ахуйн нэгж байгууллагын ажлыг дүгнэх журам”-ын дагуу 2012 оны ажлаар сумдаас Бөхмөрөн, Ховд, Наранбулаг сумдыг, агентлагуудаас БСГазар, ЭМГазар, Статистикийн хэлтсийг тус тус шалгаруулан 1-3-р байр эзлүүлэн батламж, мөнгөн шагнал, дээрх сум, байгууллагуудын удирдлагыг сарын үндсэн цалингийн 50%-иар, “Монгол улсын сайн малчин” цолоор Хяргас сумын Бугат багийн малчин Цээсүрэнгийн Цэндээ, Зүүнговь сумын Өгөмөр багийн малчин Тогоонямын Төгсжаргал, Тэс сумын 1-р багийн малчин Гомбожавын Дорж, “Улсын тэргүүний тариаланч” цол, тэмдгээр Тариалан сумын Ө.Агваандорж нар шалгарч шагнууллаа.

Мөн оны тэргүүний үйлдвэрлэгч байгууллагаар Баруунтуруун сумын “Хөгжил- Увс”ХХК-ыг, худалдаа үйлчилгээний байгууллагаар Зүүнговь сумын “Ногоон худаг” хоршоо, үйлчилгээний байгууллагаар Улаангом сумын 1-р цэцэрлэг, Зүүнговь сумын эрүүл мэндийн төв, тэргүүний ТББайгууллагаар аймгийн ахмад багш нарын холбоог, татвар төлөгч байгууллагаар “Сантех Увс” ХХК-ыг тус тус шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар, аймгийн сайн малчинаар сум бүрээс 1-ээс доошгүй буюу 20 малчныг шалгаруулан энгэрийн тэмдэг, хаяг бүхий цар, мөнгөн шагналаар, ажил мэргэжлийн болон салбарын тэргүүнийг 18 төрлөөр шалгаруулж энгэрийн тэмдэг, хаяг бүхий цар, мөнгөн шагналаар тус тус шагнасны дээр мөн аймгийн ИТХ-аас 2012 онд баяр ёслол тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан НӨУБайгууллага, нутгийн захиргаа, ТББ-уудын ажилтан сонгуультай нар болон бүх салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид, хувиараа хөдөлмөр, бизнес эрхлэгчдийн төлөөлөл болох 6 хүнийг аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”, 7 хүнийг “Баярын бичиг”, 1 хүнийг “Талархал” мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна.

Увс аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийдүүдийн судалгааг шинэчлэн гаргаж, энэ асуудлаар аймгийн ИТХ-аас шинэчилсэн журам батлан гаргаж, түүний хэрэгжилтэнд үзлэг явуулж, үйл ажиллагаа явуулах эрхийг шинэчлэн олгож, зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай сунгадаг болж энэ журмын хүрээнд Баруунтуруун сумын Жанрайсаг дацанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх зөвшөөрлийг олголоо.

2013 оны эхний хагас жилд аймгийн ИТХ-аас онцлон анхаарч зохион байгуулсан зарим онцлог ажил, түүний үр дүнгээс дурьдвал:


Аймгийн НӨУБайгууллагуудын ажлыг өөрчлөн сайжруулах зорилтын хүрээнд иргэдийн өөрсдөө сонгон байгуулсан байгууллага болох бүх шатны Иргэдийн хурлууд нь бүх ажлынхаа төвд иргэн хүнийг тавьж тэдэнд чирэгдэлгүй, шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх арга барилыг нэвтрүүлж, иргэдийнхээ оролцоонд түшиглэж ажиллаж, орон нутгийн түвшинд төсөл хөтөлбөрийн шугамаар хийгдэх ажлууд болон орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг сонгож, ач холбогдолоор нь эрэмблэн, багийн иргэдийн нийтийн хурлын албан ёсны шийдвэр гарган ИТХ-уудад батлуулахаар өргөн мэдүүлсэн.

Хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил, төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах, хэрэгжиж байгаа ажлын гүйцэтгэл, материалын чанар, стандарт хангалт, төсвийн зарцуулалтын байдалд нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдээс хяналт тавих ажлыг гүйцэтгэх олон нийтийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулж, уг ажлыг хүлээн авахдаа тэдний санал дүгнэлтийг гаргуулан авах, харгалзан үздэг болох зэрэг асуудлаар аргачилсан зөвлөмж гарган сумдын ИТХ-д хүргүүлж хэрэгжүүлсэн.

Судлан боловсруулах, мэдээлэн тайлагнах, сурталчилгааны ажилд ихээхэн ач холбогдол өгч энэ чиглэлийн ажлыг 2013 оны ажлын төлөвлөгөөнд тусгай бүлэг болгон тусгасан .

Мөн иргэдийн дунд тулгамдаж, яриа шүүмжлэлд ихээр өртөж байгаа асуудал, түүнтэй холбоотойгоор авч хэлэлцэхээр, шийдвэр гаргахаар төлөвлөж байгаа зарим асуудлаар олон нийтэд хандсан зарлал мэдээллийг урьдчилан тарааж, тухайн асуудлаар ажилладаг мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, тэдгээрийн удирдлага, мэргэжилтнүүдийг урьж, асуудал танилцуулах, санал бодлоо илэрхийлэх талуудын байр суурийг дэлгэрэнгүй сонсож хөндөгдсөн асуудлыг гарах шийдвэр, бодлого зорилтонд хэрхэн тусгах талаар аймгийн ИТХ-ын болон хурлын хороодын дарга, Засаг дарга, хэлтэс, газруудын удирдлага байр суурь, саналаа харилцан танилцуулах, гарсан асуултанд нь хариу өгөх журмаар нээлттэй хэлэлцүүлгийг иргэний танхимд аймаг, сумын ИТХ-уудаас зохион байгуулсан. Аймгийн ИТХ, иргэний танхим, Улаангом сумын Засаг даргын тамгын газар хамтран Улаангом хотын өнгө үзэмжийг сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт нийт 100 гаруй иргэн оролцож 44 орчим санал гаргасныг хийх ажлын төлөвлөгөөнд тусган, хариу өгөх арга хэмжээ авав. Сумдын иргэний танхимаар 28 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж 1493 иргэн оролцож 120 санал гарсан байна. 166 иргэнд эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Иргэний танхимын Хэлэлцүүлгээр хэлэлцсэн асуудал



Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны тасралтгүй байдал, бэлтгэл, зохион байгуулалтаар хангах үүрэгтэй ажлын албаны үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд аймгийн ИТХ-ын жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хуралдааныг бэлтгэж зохион байгуулах, түүний бичиг баримт, гаргах шийдвэрүүд, бусад байгууллагуудтай харилцах, хариу өгөх, харилцан ажилладаг байгууллагуудад хүргүүлэх тайлан мэдээ зэрэг аймгийн ИТХ-ын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулахын зэрэгцээ хурлын төлөөлөгчид, сум, багийн Иргэдийн хурлуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах 14,0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, ажлын албаны 6 өрөөнд 17,4 сая төг-ийн их засвар, тохижилт хийж, Хурлын парк шинэчилэн land cruiser- 200 автомашинтай боллоо.

Багийн ИТХ-ын ажилд ахиц өөрчлөлт гарах үндэс суурь тавигдаж түүнд оролцох иргэдийн оролцоо ч дээшлэх хандлагатай боллоо. Багийн ИТХ-ын дарга орон тооны бус ажиллаж байгаагаас шалтгаалан Хурлын ажил багийн түвшинд төлөвшин ажиллаж чадахгүй байна. Иймд багийн ИТХ-ын даргыг багийн засаг даргатай адилхан шалгуураар сонгож орон тооны болгож, цалин урамшууллыг ижилхэн олгохоор хуулинд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-аас баталсан журмын дагуу Шинэ Үндсэн хууль батлагдсан өдрийн шатрын тэмцээнийг "Аймгийн ИТХ-ын нэрэмжит" ажил болгон санхүүжүүлж тэмдэглэн өнгөрүүлсэн. 2013 оны 5-р сард Наранбулаг сумын 3 багийн ИТХ хуралдаж багийн ИТХ-ын дарга, тэргүүлэгчид,

багийн Засаг дарга нарын сонгуулийг зохион байгуулснаар бүх багийн удирдлагыг шинээр сонгож зохион байгуулах ажил дуусав.

Хоёр. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаан

2013 оны эхний хагаст аймгийн ИТХ-ын хуралдаан 2 удаа хуралдаж 5 асуудлыг хэлэлцэж 33 заалт бүхий 5 тогтоол гаргаж төлөөлөгчид дунджаар 81,7% -ийн ирцтэй оролцож давхардсан тоогоор 57 төлөөлөгч санал шүүмжлэл гаргаснаас 51 санал хурлын шийдвэрт туссан байна.

Аймгийн ИТХ-ын 6 дахь удаагийн сонгуулийн **3-р хуралдаан** 2013 оны 1-р сард хуралдаж аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай аймгийн Ерөнхий прокурорын мэдээлэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг дэмжих, аймгийн 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тус тус хэлэлцэв.

1-р сарын 28-нд дээрх асуудал тус бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулж Хурлын хороод хамтарсан санал дүгнэлт гарган хуралдаанд оруулав.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус **4-р хуралдаан** 5-р сард хуралдаж аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон Түмэнжаргалын Болдын бүрэн эрхийг зөвшөөрөх, аймгийн 2013 оны төсөвт тодотгол хийх асуудлыг авч хэлэлцэж төлөөлөгч Т.Болдын бүрэн эрхийг зөвшөөрч тогтоол гаргаж, төлөөлөгчийн үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Аймгийн ИТХ-ын төсвийн тодотголыг хэлэлцэн ОНХС-аас улсын төсвийн байгууллагуудын хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан 433.2 сая төгрөгийг Улаангом сумын ахлах 1-р сургуулиас Тэнгис үйлчилгээний төвийн урд худаг хүртэл бохир усны гол шугам татах, эрүүл мэндийн цогц суурь үйлчилгээг хөдөөгийн иргэдэд үзүүлэх, хөл бөмбөгийн талбай байгуулах, шинэ цэцэрлэгийн гадна инженерийн шугам сүлжээний холболт, Увс нуурын аялал жуулчлалын баазын чиглэлийн устай жалганд бетон хоолой тавих, Тэс сумын эрүүл мэндийн төвийн дээврийн засварын ажилд хуваарилав.

Урьд оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 577.2 сая төгрөгийг ХХОАТ-ын буцаан олголт, Нэгдсэн эмнэлгийн автомашины зогсоолыг өргөтгөх, “Залаахайрхан” үйлчилгээний төвийн өмнөх талбайд таксины зогсоол байгуулах, боловсролын салбарт үүсээд байгаа цалин, шимтгэлийн өрийг барагдуулахаар шийдвэрлэж тогтоол гаргалаа.

Боловсролын салбарт үүсээд байгаа цалингийн өрийг шийдвэрлэх талаар Улаангом сумын 3-р багт шинээр ашиглалтанд орох цэцэрлэгийн ашиглагдаагүй хугацааны 1-5 сарын цалин, шимтгэл 59.8 сая төгрөгийг, мөн цэцэрлэгийн хоолны зардлаас 14.1 сая төг-ийг нүүдлийн цэцэрлэгийн хоолны зардалд, ЕБС-ийн хоол, үдийн цайны хэмнэгдэлээс 249,4 сая, хуваарилагдаагүй зардлаас 147.2 сая төг-ийг тус тус цалин, шимтгэлд шилжүүлэх, хуваарилагдаагүй бусад зардлаас хөдөө орон нутгийн нэмэгдэл авч чадаагүй 5 багшид 11.6 сая, өндөр насны тэтгэвэрт 3 багшийн тэтгэмжийн зардалд 44.3 сая, морин хуур хөтөлбөрт 100 сая, ном хөтөлбөрт 27.1 сая төг зарцуулахаар болж хуралдаанаас тогтоол гаргалаа.

Хуралдааныг 1 сараас доошгүй хугацааны өмнө товлон зарлаж, хэлэлцэх асуудлыг тогтсонтой холбоотойгоор хурлын ажлын албанаас түүний бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гаргаж, хуралдаанд оруулах асуудлыг боловсруулж Засаг даргын захирамжаар ажлын хэсгүүдийг томилон ажиллуулж, бэлтгэсэн төслүүдийг Засаг даргын зөвлөл, хурлын хороод болон тэргүүлэгчдийн хуралдаанаар урьдчилан хэлэлцэж өгсөн чиглэлийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулан эцсийн хувилбарыг бэлтгэж, хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хурлын хороод, төлөөлөгчдөд хүргүүлж, улмаар хурлын хороод болон төлөөлөгчдөөс асуудал оруулагчидтай ярилцлага хийж нэмэлт мэдээлэл, тайлбар өгүүлэх ажлыг зохион байгуулсны дараа хурлын хороод өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах буюу хувиарлагдсан асуудлаараа хуралдаанд оруулан танилцуулах санал дүгнэлт, тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд тусгах саналаа бэлтгэн хуралдаанд оруулахаар бэлтгэл ажлыг зохион байгуулж ирлээ.

Газар зохион байгуулалт, хотын дахин төлөвлөлт, багийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зэрэг асуудлуудыг багийн ИНХ-аар хэлэлцүүлэх, хуралдаанаар хэлэлцэж ирсний дээр хуралдааны өмнө нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, асуудал эрхэлсэн хороод, холбогдох ажил мэргэжлийн болон иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөллийг урилгаар оролцуулан санал бодол, байр суурийг нь сонсож, хэлэлцүүлгээр шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудыг тодруулан түүнийг аймгийн ИТХ-ын хуралдааны шийдвэр болон цаашдаа Засаг даргын үйл ажиллагаа шийдвэрүүдэд хэрхэн тусгаж хэрэгжүүлэх арга замуудыг тодруулан авч үзэх, хэлэлцүүлгийн явц, хуралдааны бусад бэлтгэл ажил болон хуралдааныг телевизээр шууд нэвтрүүлэн, нээлттэй утас ажиллуулж иргэдийн санал, хүсэлтийг авах зэргээр хуралдааны аж ахуй, үйлчилгээ, зохион байгуулалт, мэдээлэл сурталчилгаа, төлөөлөгчдийг мэдээллээр хангах, хуралдааныг ажил хэрэгч, тогтоосон цагт багтааж үр нөлөөтэй явуулах бүх талын бэлтгэлийг сайтар хангаж хийлээ.

Нийтдээ хороо тус бүр 2-3 удаа хуралдаж, 1-4 удаа санал дүгнэлт гаргаж, 4 хүртэл асуудлыг боловсруулан шийдвэрлүүллээ.

Гурав. ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаан

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг сонгож төлөвлөхдөө аймгийн ИТХ-ын хуралдаанаас баталсан аймгийн ирээдүйн хөгжлийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэд хөтөлбөр, төлөвлөгөө, нийгэм эдийн засаг, бүтээн байгуулалтын ажлуудын хэрэгжилтийг хангахад голлон анхаарч ажиллав.

Аймгийн Тэргүүлэгчдийн хурлын хуралдааныг сард 1-ээс доошгүй хуралдуулж байхаар төлөвлөснөөс 8 удаа хуралдуулж төлөвлөсөнөөс гадна цаг үеийн ажлын шаардлагаар бусад 13, бүгд 25 асуудлыг хэлэлцэн 52 заалттай 27 тогтоол гаргаж холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, үр дүнд нь хяналт шалгалт хийж ажиллалаа.

Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах тухай хэлэлцээд Сүхбаатарын одонгоор шагнуулахаар 1, Ардын багш цолоор -2, Гавьяат цолоор шагнуулахаар 13, Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 15, Алтан гадас одонгоор 92, Хөдөлмөрийн Хүндэт медалиар 41, Цэргийн гавьяаны одонгоор 1 хүн, “Алдарт эх” 1-р зэргийн одонгоор 79 эх, “Алдарт эх” 2-р зэргийн одонгоор 353 эхийг тус тус шагнуулахыг дэмжиж Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж уламжилснаас Цэргийн гавьяаны одонгоор 3, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 7, Алтан гадас одонгоор 46, Хөдөлмөрийн Хүндэт медалиар 40 хүн, “Алдарт эх” 1-р зэргийн одонгоор 67 эх, “Алдарт эх” 2-р зэргийн одонгоор 335 эх, Аймгийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөлөөр 6, баярын бичгээр 7, “Талархал”-аар 1 хүн тус тус шагнагдлаа.

Орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Улаангом сумын 3-р багийн нутагт нийтийн орон сууцны зориулалтаар 6 байршилд 5400м² талбайг эзэмшүүлэхээр шийдвэрлэлээ. Улаангом суманд баригдах 3-р 16 айлын орон сууцнаас боловсролын салбарын ажилтнуудад 6, эмнэлэгт 4, цагдаагийн газарт 2, аймгийн ЗДТГ-т 4 квот тус тус хуваарилав.

Аймгийн ГХУСАЗЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж ажиллах журмыг Хурлын энэхүү бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд нийцүүлэн өөрчлөлт оруулан шинэчиллээ. Аймгийн ИТХ-ын худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны ажлын төлөвлөгөөг батлав.

Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журамд “Үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, машин механизм 1.5сая төгрөгнөөс доош үнэтэй тоног төхөөрөмжөөс бусад элэгдлийн хугацаа, хэмжээгээр анхны үнээ нөхсөн, сэргээн засварлах боломжгүй эд хөрөнгийг актлах тухай асуудлыг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор шийдвэрлэхээр өөрчлөлт оруулав.

Аймгийн төв Улаангомыг улсын зэрэглэлтэй хот болгохыг дэмжиж, аймгийн төсвийн тодотгол, нийгмийн эрүүл мэндийн зөвлөл байгуулан ажиллах журам батлаж, орон нутгийн өмчийн асуудал хэлэлцэв. Нийгмийн эрүүл мэндийн зөвлөлийг 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зөвлөлийн ажиллах журмыг баталлаа.

Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын танилцуулга, шийдвэрийн төслийг, төлөвлөгөөний хамт хурал болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө тэргүүлэгчдэд цахим хэлбэрээр, шаардлагатай үед цаасан хэлбэрээр хүргүүлж, хуралдаан дээр асуудлыг танилцуулахад техник хэрэгсэлийг өргөн ашиглаж байна. Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцсон, хяналт шалгалт, боловсруулалтын ажил болон хурлын хороодыг удирдаж тодорхой чиг үүргийг гүйцэтгэсэн байдлыг нь үндэслэн улирлаар тооцож 90000 төгрөгийн урамшуулал тэргүүлэгчдэд олгож, орон нутагт хийх мэдээлэл сурталчилгаа, хяналт шалгалтын ажлуудад байнга оролцуулж байна. Тухайлбал: аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс сумдын ажилд хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөх 9 ажлын хэсэгт оролцож, сумдад явж ажилласны дээр, тэргүүлэгчид болон нийт төлөөлөгчид сонгогдсон сум, тойргийнхоо ИТХурал багийн ИНХ-

уудад тогтмол оролцож сонгогчдын санал хүсэлтийг сонсож, хийсэн ажлынхаа тайланг танилцуулж байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны ажлын төлөвлөгөөнд бусад сум байгууллагатай холбоотойгоор тусгагдсан асуудлыг холбогдох талуудад 1 сараас доошгүй хугацааны өмнө мэдэгдэж бэлтгүүлж, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх “Олон нийтэд түшиглэсэн халамж үйлчилгээний ажлын чанар хүртээмжийн байдал, цаашдын чиг хандлага, Увс аймагт хүүхдийн талаар хэрэгжүүлж байгаа бодлогын зорилтууд, хүүхдэд эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх талаар цаашид авах арга хэмжээний тухай мэдээллийг аймгийн ИТХ-ын Иргэн болон нутгийн удирдлага, бусад байгууллагатай харилцах хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн болон Хүн амын эрүүл бүтээлч хөдөлмөрлөх орчин бүрдүүлэх, нийгмийн хөгжлийн асуудал эрхэлсэн хороод, аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийн бүлгээр тус тус хэлэлцүүлж, холбогдох байгууллагын удирдлагуудад үүрэг чиглэл өгч, зарим ажлыг нэмж зохион байгуулахыг даалгаж, эмэгтэй төлөөлөгчдийн хэсэг газар дээр нь очиж танилцах зэрэг ажлыг ажлын албанаас өгсөн удирдамжийн дагуу хийлээ.

Дөрөв. Хяналт шалгалтын ажил

Хяналт шалгалтын ажлыг сайтар зохицуулан, зохион байгуулж, түүний үр нөлөөг өндөржүүлэх асуудалд зөвхөн аймгийн ИТХурал төдийгүй холбогдох мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулахад анхаарч байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаан дээр гарсан санал шүүмжлэл, иргэд байгууллагаас ирүүлсэн хүсэлт мэдээлэл, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрүүдтэй холбоотойгоор жил бүрийн ажлын төлөвлөгөөнд аймгийн ИТХ-ын ажлын алба, хурлын хороод, тэргүүлэгчдээс мөн аудитын газар, мэргэжлийн хяналтын газар бусад эрх бүхий байгууллагуудаар хийлгэх үзлэг шалгалтуудыг тусгаж, хийсэн үр дүнтэй нь танилцаж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна.

Аймгийн ИТХ-аас Аудитын газраар аймгийн музей, номын санд нийцлийн аудит, аймгийн төвийн 61 төсөвт байгууллагад шатах, тослох материал, сэлбэг хэрэгслийн худалдан авалт, зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлгэх захиалга өгч, төлөвлөгөө хуваарь гаргуулан хийлгэж эхлээд байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн эрүүл мэндийн зөвлөх Ж.Цогтсугар манай аймагт Архидан согтуурлыг бууруулах, архигүй аймаг болоход Төрийн байгууллагуудын удирдлагын сэтгэлгээ болон Иргэдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх зорилгоор «Сэтгэлгээний шинэчлэл» сэдвийн хүрээнд сургалт зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын хуралдаан дээр гарсан санал шүүмжлэл, иргэд байгууллагаас ирүүлсэн хүсэлт мэдээлэл, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрүүдтэй холбоотойгоор 2013 оны ажлын төлөвлөгөөнд 14 багц асуудлаар үзлэг, хяналт шалгалтын ажил хийхээр төлөвлөсний 8-г нь аймгийн ИТХ-аас, 6-ыг нь аудитын газрын төлөвлөгөөнд нь тусгуулан,

аймгийн ИТХ-ын холбогдох хороод, тэргүүлэгчид, төлөөлөгчид болон ажлын албаны мэргэжилтнүүдийн оролцоотойгоор зохион байгуулахаар төлөвлөж хэрэгжүүлж байна.

Аймгийн ИТХ-ын ажлын алба, хурлын хороод, ГХУСАЗсалбар зөвлөл, ОНӨмчийн албанаас сумдын ИТХ-ын ажлын түвшинд хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөх, шаардлагатай сумд, багийн ИНХ-ын ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, НӨУБайгууллагын ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэг, техник хэрэгсэл ашиглах чадвар, боловсролын шаардлага хангалт, түүнийг илэрхийлсэн бичиг баримтын байдалд үзлэг явуулах, сүм хийдүүдийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг хангуулах, байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого бүртгэл, сум байгууллагуудад орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт, зарцуулалт, өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг шалган танилцах, илүүдэлтэй, ашиглалтгүй байгаа өмч хөрөнгийг шийдвэрлэх, тодорхой хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцах зэрэг асуудлаар нийтдээ ажлын хэсэг ажиллах үеэр үзлэг шалгалт явуулж, түүнд бүх сумд, холбогдох байгууллагууд хамрагджээ.

ОНӨ-ийн бүртгэл тооллого, ашиглалт хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулж, зөвхөн 2013 онд илүүдэлтэй ашиглалтгүй байгаа орон нутгийн өмчийн барилга байшин, машин мотоцикл, техник хэрэгсэл, бусад объектүүдийн талаар суманд ажилласан ажлын хэсгүүд судалгаа явуулж, тус албанаас боловсруулсан саналыг үндэслэн тэдгээр өмчийг актлах, шилжүүлэх, худалдан борлуулах асуудлаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр 3 удаа хэлэлцэж, зохих шийдвэр гаргасны дээр ОНӨ-ийн 26610,0 сая төгрөгийн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдан борлуулахаар нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж 30170,0 сая төгрөгийн орлогыг аймгийн ОНӨ-ийн санд төвлөрүүлсэн. Мөн 108900.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасаж, 660051,9 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн.

Өмнөх оны 1830.0 мян төг-ийн авлагыг барагдуулж, байрны талбайн түрээсийн гэрээг байгуулж 5214.2 мян төг-ийн түрээсийн орлого оруулсан. ОНӨмчит төсөвт байгууллагуудын 2012 оны өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, сумдын орон нутгийн өмчит 112 хуулийн этгээдийн 2013 оны өмч эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан.

Хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн сангийн ашиглалтыг сайжруулах, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд хяналт тавих, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг цаг тухай бүр бүртгэн тайлагнах, ялангуяа улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, тусламжаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах, хөрөнгийн үнэлгээг сайжруулахад аймгийн ИТХ-аас ажлын хэсэг ажиллан хяналт тавьж, цаашид ч хянаж ажиллахыг сумын ИТХ-д чиглэл өгсөн.

Өмнөговь, Зүүнговь, Ховд, Завхан, Цагаанхайрхан сум хагас, бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан худалдах, актлах хөрөнгийн саналыг аймгийн ОНӨ-ийн албанд хүргүүлэн шийдвэрлүүлж ажилласан байна.

ГХУСАЗЗ-ийн хурлыг 2 удаа хуралдуулж аймгийн хуралдаанд тавих ерөнхий прокурорын мэдээллийг хэлэлцлээ. Аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгч, удирдах ажилтан 522 албан тушаалтны 2012 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим мэдээллийн санд орууллаа.

ГХУСАЗЗ-ийн 2012 оны ажлын тайланг Хууль зүйн яаманд, 2012 оны орон нутгийн сонгуулиар байгуулагдсан аймаг, сумдын ИТХ-ын бүтэц, бүрэлдэхүүний судалгааг 11 маягтын дагуу гаргаж ЗГХЭГ-т, Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсэг байгуулсан сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолын нэгтгэлийг СЕХ-нд тус тус хүргүүллээ.

Аймгийн ИТХ-аас нэгтгэн зохион байгуулж байгаа хяналт шалгалтын ажлын ихээхэн хэсэг нь аймгийн ГХУСАЗСалбар зөвлөлийн шугамаар зохицуулагдан хийгдэж ирлээ. Үүнд: Аймгийн ГХУСАЗСалбар зөвлөл 2013 онд 6,8 сая төгрөг, сумууд ГХУСАжилд 20 гаруй сая төгрөгийн төсөвтэй ажиллаж байгаа ба “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд цагдаагийн газраас зохион байгуулсан “Сургууль –аюулгүй орчин 2” сарын арга хэмжээний уралдааны шагналд 383000 төг, аймгийн прокурорын газраас зохион байгуулсан иргэдэд хууль сурталчлах, 2012 онд үйлдэгдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийг таниулах, тухайн нутгийн гэмт хэргийн талаарх омдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг шалгаж байгаа ажиллагааны талаар иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах, газар дээр нь шийдвэрлэх арга хэмжээнд 500000 төгрөг, архидан согтуурахтай тэмцэх сургалтын багш, Аддиктологийн нийгмийн ажилтан нарыг урьж ирүүлэх унааны зардалд 500000 төгрөг зарцуулж хамтран ажиллалаа.

Аймгийн ГХУСАЗЗ-өөс санаачлан Увс аймгийн шүүх, прокурор болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн хийж хамтын ажиллагааг сайжруулах, хилийн зөрчлийг багасгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл харилцан солилцох, хохирол барагдуулах зорилгоор зөвлөмж гаргасан. Уг зөвлөмжийн дагуу Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг сумдад сурталчлах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гарсан гомдол, хүсэлтэд хуульзүйн үндэслэлтэй, дэлгэрэнгүй хариулт өгөх, гэмт хэрэг зөрчилд холбогдсон этгээдийн шилжилт хөдөлгөөн, эрэн сурвалжлах ажиллагааны талаарх мэдээллийг шуурхай солилцох, хамтран ажиллах, хөрш ОХУ-ын Тыва улсын хууль хяналтын байгууллагуудтай хилийн уулзалт зохион байгуулах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагааны чанар, үр дүнд онцгой анхаарч ЭБШХ болон УЕП-ын баталсан зааврыг нэг мөр хэрэгжүүлэн ажиллахаар болж прокурорын байгууллага тусгай удирдамжийн дагуу бүх суманд ажилласны тээвэр шатахууны зардлын 400000 төгрөгийг аймгийн ИТХ-ын ГХУСА-ын зардлаас санхүүжүүллээ. Сум бүр цагдаагийн кабонтай болсноор тэнд ажиллаж буй цагдаагийн албан хаагчдын тогтвор суурьшилтай, тав тухтай амьдрах нөхцөл эрс дээшилж, унаа, машины хангамж сайжирч, идэвх санаачлагатай ажилласны үр дүнд гэмт хэрэг зөрчлийн гаралт 2012 оны 6-р сараас 19 нэгж буюу 11.38 хувиар, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмтхэрэг 3-аар буюу 42.86%, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 1-ээр буюу 33.33%, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 29-өөр буюу 34.52%, үүнээс бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 22-оор буюу 30.56%, малын хулгай 23-аар буюу 46.94%, бусад хулгайн хэрэг 5-аар буюу 83.3%, завших, үрэгдүүлэх хэрэг 3-аар буюу 75%-

иар, танхайн хэрэг 2-оор буюу 25% -аар буурч, залилан мэхлэх, аж ахуйн нэгжийн эсрэг, эд зүйл хууль бус аргаар хил нэвтрүүлэх хэрэг гараагүй байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 5-аар буюу 62.5%, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 3-аар буюу 150% нэмэгдэж, урьд нь гарч байгаагүй хүнийг санаатай алах гэмт хэрэг 1, дээрэм 3, булаалт 1, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 1 шинээр гарсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хилийн малын хулгайтай тэмцэх ажилд хилийн бүсийн багийн иргэдийг оролцуулж ажиллахаар багийн Засаг дарга нартай Хилийн цэргийн ангиуд хамтарч хэлэлцүүлэг зохион байгуулав. Зохион байгуулсан арга хэмжээний гол зорилго нь улсын хил хамгаалалтад сайн дурын үндсэн дээр оролцох иргэдийг ажил үйлдвэрлэл явуулж буй байдлаар нь байнгын болон түр хугацаагаар хил хамгаалах туслах хүч болгон зохион байгуулах, Монгол Улсын иргэн хилийн тухай хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангаж хамтран ажиллахаар болов.

Улсын хил хамгаалалтын ангиуд болон аймгийн ИТХ, хууль хяналтын байгууллагын удирдлагуудаас хил хамгаалалтын талаар аймаг орон нутгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид ажил эрчимжүүлэх тухай уулзалт семинарыг сумдын багийн засаг дарга нарт зориулан зохион байгуулж мэдээлэл солилцож санал, хүсэлтээ илэрхийлэв.

Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар хэсгийн төлөөлөгч, цагдаа нартай хамтран тамхины тухай хуулийг хэрэгжүүлэн сумын сургууль, цэцэрлэгээс 500 м-ийн дотор байрлах дэлгүүрийн тамхи худалдах эрхийг зогсоож, албан газар, аж ахуйн нэгж, олон нийтийн газар тамхи хэрэглэхгүй байх санамж зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэн сурталчлан ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын ажлын албанаас авилгатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах талаар 2013 онд хийх ажлын төлөвлөгөө гарган, шударга ёс, ил тод байдлыг бэхжүүлэх "Ил тод байдлын самбар" ажиллуулдаг боллоо.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын бодлого, шинэчлэл" аймгийн зөвлөгөөн зохион байгуулагдаж хөгжлийн бэрхшээлтэй иргэд тулгамдсан асуудлаа хэлэлцэж, нэгдсэн чуулганд аймгийн төлөөлөл оролцов.

Аймагт хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд хийх бүтээн байгуулалтын ажлуудын талаар Аудитын дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, түүнд саналаа тусгуулав

Аймгийн ИТХ-ын хуралдаан дээр төлөөлөгчдийн гаргасан санал шүүмжлэлийг холбогдох газруудад хүргүүлж, зохион байгуулсан ажлын тайланг авч мэдээлэл бэлтгэн төлөөлөгч бүрт цахимаар болон цаасаар хүргүүллээ.

"Шууд Ардчилал-Иргэдийн оролцоо" жилийн ажлын хүрээнд МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газрын ажилтнууд Увс аймгийн сумуудаар ажиллах үйл ажиллагаанд зохион байгуулж дэмжлэг

үзүүлэн нийт 3000 гаруй иргэдтэй уулзуулав.

2014-2016 онд Увс аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар СУМ хөтөлбөрийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг тодорхойлох 4 яамны мэргэжилтэнүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэв. Иргэдийн хэлэлцүүлэгт аймгийн хэмжээнд 2753 иргэн оролцож санал өгсөн байна.

Аймгийн ИТХ-д хувь хүн, албан байгууллагаас нийт 194 албан бичиг, санал хүсэлт ирснийг судлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авч хариу өглөө.

Аймгийн ИТХурал, тэргүүлэгчид, төлөөлөгчдөөс гаргасан санал, шүүмжлэл, шийдвэрүүдийн биелэлтэнд хяналт явуулан дүнг аймгийн ИТХ-ын хуралдаан дээр тайлагнаж танилцуулж, дэлгэрэнгүй танилцуулгыг нь цаасаар болон цахимаар тараасан.

Сумын ИТХ-ууд ил тодын самбар гаргаж төсвийн зарцуулалт, Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийн зарцуулалт, Хурлын шийдвэр, түүний хэрэгжилтийн байдлыг иргэдэд ил тод болгож, Давст, Ховд, Хяргас, Сагил, Өндөрхангай, Зүүнхангай сумын Хурлын Хороод “Үдийн цай” хөтөлбөр, дотуур байрны болон эмнэлэг, цэцэрлэгийн хоолны чанарт хяналт шалгалт явуулж хяналт шалгалтын ажил хийсэн нь үр дүнтэй болсон байна.

Сумдын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж сумын ГХУСАЗЗ-ийн нарийн бичгийн дарга нь сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга байхаар аймгийн ГХУСАЗЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж сумдын салбар зөвлөлүүдийн ажлыг тогтмолжуулах, мэдээ тайлан, албан хэргийг нь цэгцлэн журамлаж, сумуудад ажиллаж буй олон нийтийн байцаагч, аймгийн төвийн төсөвт газруудад ажиллаж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил харицсан ажилтны судалгааг шинэчлэн гаргаж тэдэнд зориулсан сургалт, семинар зохион байгууллаа.

Тав. Бусад ажил

Аймгийн ИТХ-ын дэргэд ГХУСАЗСЗөвлөл, ЦАУЗБСКомисс, Монголын НУХолбооны салбар, ОНӨАлба зэрэг ажил төрлийн уялдаа холбоо бүхий нэгжүүд ажиллаж, тэдний ажил нь аймгийн ИТХ-ын нийт ажлын үр дүнд нөлөөлж байдаг.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн амьд сэрүүн байгаа ач, зээ 467 хүний судалгааг гаргаж ЦАУЗБ улсын комиссын ажлын албанд хүргүүлсний дээр 30 гаруй иргэнийг, 11 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх арга хэмжээ авч 1 иргэнд нэг сая төгрөгийн нөхөн олговор, 2 иргэнд цагаатгалын үнэмлэх, 6 иргэнд лавлагаа олгуулж 1 иргэний нэхэмжлэлд нөхөн олговор олгуулах шийдвэр гаргуулахаар шүүхэд хүргүүлж, семинари мэдээлэл сурталчилгаа, судалгааны олон арга хэмжээг явуулж байна.

Мөн 2014-2015 онд Увс нутгаас төрсөн төр нийгмийн зүтгэлтэн Ө.Бадрахын дурсгалд зориулсан эрдэм шинжилгээний бага хурал хийх, түүний нэрэмжит цэцэрлэгт хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөө босгох, ном товхимол хэвлүүлэх зэрэг 80 гаруй сая төгрөгийн зураг

төсөв хийлгэх, загвар бүтээх, боловсруулалтын ажлын төсөл боловсруулан шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад хүргүүлээд байна.

Монголын НУХолбооны аймгийн салбараас холбооны гишүүн, дэмжигч байгууллагын дунд явуулах зохион байгуулалт, санхүү аж ахуй, мэдээлэл сурталчилгааны олон талт ажилд байнга анхаарч , идэвхитэй оролцож ирсэн ба Нутгийн удирдлага сэтгүүлийн захиалгыг нэмэгдүүлэх, түүнд өөрсдийн ажлын туршлага, танилцуулгаа хэвлүүлэх, багийн ИНХ-ын дарга, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ширээний ном - харилцан туршлага солилцох, гарын авлага болгож ашиглахад анхааран ажиллаж байна.

Тайлан бичсэн : Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн

Нарийн бичгийн дарга

/Б.Оюунбат/

Танилцсан : Увс аймгийн ИТХ-ын дарга

/ Ч.Чимэд /